



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшний биелэлтийг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхагва-Очир)-т даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Л.Амгалан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА